



БАТЛАВ  
АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
*(Signature)* М.МӨНХӨӨ



БАТЛАВ  
ЦОГ ЗОРИГ ХХК-ИЙН ЕРӨНХИЙ  
ЗАХИРАЛ  
*(Signature)* Х.ЦЭВЭГЖАВ

## ЭРЧИМ ХҮЧНИЙ ИЖ БҮРЭН АУДИТ ХИЙХ ГЭРЭЭ

Улаанбаатар хот

2023/62

2023 оны 07 сарын ... 07

Монгол Улсын Иргэний хууль, Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын 2019 оны 181 дугаар тогтооолоор батлагдсан “Аудит хийх журам”-ыг тус тус удирдлага болгон нэг талаас Монгол Улсын аж ахуйн нэгжийн бүртгэлийн 6021646 регистрийн дугаартай Амгалан дулааны станц ТӨХК (цаашид “ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ” гэх) түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал М.Мөнхөө, нөгөө талаас АМИ-008/2018 дугаар магадлан итгэмжлэл бүхий аудитын байгууллага (цаашид “ГҮЙЦЭТГЭГЧ” гэх), түүнийг төлөөлж Ерөнхий захирал Х.Цэвэгжав нар (цаашид хамтад нь “ТАЛУУД” гэх) дараах нөхцлүүдийг харилцан тохиролцож энэхүү эрчим хүчний аудитын гэрээ (цаашид “ГЭРЭЭ” гэх)-г байгуулав.

### Нэг. Гэрээний зорилго

1.1. Энэхүү гэрээгээр аудитын ажлын хүрээ, тооцооны аргачлал, хэмжилтийн багаж хэрэгсэл, аудитын үйлчилгээний хэлс, гүйцэтгэх, үр дүнг хүлээлгэн өгөх хугацаа, аудитын үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлагыг зохицуулна.

### Хоёр. Ерөнхий нөхцөл

2.1. Гэрээтэй холбоотой аливаа эрх, үүрэг, хариуцлагыг гэрээлэгч талууд бүрэн хариуцна.

2.2. Гэрээнд заагаагүй талуудын эрх, үүрэг, хариуцлагатай холбоотой бусад асуудлыг Монгол Улсын хууль, тогтоомжид нийцүүлэн талууд харилцан тохиролцож тусгаж болно.

### Гурав. Аудитын үйл ажиллагаа

3.1. Аудитын үйл ажиллагааг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэнэ.

3.2. Талууд аудит хийх төлөвлөгөөг хамтран боловсруулах ба төлөвлөгөө нь энэхүү гэрээний хавсралт болно.

3.3. Төлөвлөгөөнд дараах зүйлсийг тусгана.

3.3.1 Аудитын хамрах хүрээ /audit хийх барилга байгууламж, технологийн шат дамжлага, тоног төхөөрөмжийн жагсаалт, ажлын нийт эзэлхүүн/

3.3.2. Хэмжилтийн багаж хэрэгсэл, тооцооны аргачлал /audit хийх барилга байгууламж, технологийн шат дамжлага, тоног төхөөрөмжийн онцлогоос хамааруулан аудитын үйл ажиллагаанд зайлшгүй ашиглагдах багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн жагсаалт/

**3.3.3.** Аудитын багийн бүрэлдэхүүн, ажил үүргийн хуваарь /гүйцэтгэгчийн санал болгосон аудитор болон аудитын үйл ажиллагаанд оролцогчдын жагсаалт, тэдгээрийн ажил үүргийн хуваарь/

**3.3.4.** Аудитыг гүйцэтгэх, үр дүнг хүлээлгэн өгөх хугацаа /Эрчим хүчний аудит хийх журмын 5 дугаар зүйлд заасан үйл ажиллагааг хугацаагаар эрэмбэлэн нарийвчлан тогтооно/

### **Дөрөв. Гэрээний хугацаа**

- 4.1. Энэхүү гэрээ нь 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн 2023 оны 11 дугаар сарын 01 -ний өдөр хүртэл хүчин төгөлдөр байна.
- 4.2. Гэрээний хугацаа дуусах үед гэрээний хэрэгжилтийг талууд дүгнэж, цаашид сунгах эсэхийг харилцан тохиролцно.

### **Тав. Аудитын үйлчилгээний хэлс, төлбөр тооцоо**

- 5.1. Талууд аудитын үйлчилгээний хэлсийг төгрөгөөр тохиролцов.
- 5.2. Аудитын үйлчилгээний хэлсөнд холбогдох татвар, хураамж багтсан байна.
- 5.3. Үйлчлүүлэгч нь гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулснаас хойш ажлын 05 өдөрт багтаан аудитын үйлчилгээний урьдчилгаа төлбөр болох нийт үнийн дүнгийн 50 хувьтай тэнцэх 12,275,000 /арван хоёр сая хоёр зуун далан таван мянга/-н төгрөгийг гүйцэтгэгчид төлнө.
- 5.4. Гүйцэтгэгч нь аудитын үйл ажиллагааны үр дүнг танилцуулж, баталгаажуулсан тайлан, зөвлөмжийг үйлчлүүлэгчид хүлээлгэн өгснөөр үлдэгдэл төлбөрийг нэхэмжлэх эрх үүснэ.
- 5.5. Үйлчлүүлэгч нь аудитын үйлчилгээний хэлсний нэхэмжлэхийг хүлээн авснаас хойш ажлын 15 өдрийн дотор гүйцэтгэгчид төлнө.
- 5.6. Талууд харилцан тохиролцсоны дагуу гэрээнд зааснаас бусад нэмэлт ажлуудыг гүйцэтгэсэн бол ажлын хэлсийг тусгай нэмэлт гэрээний дагуу төлнө.

### **Зургаа. Талуудын эрх, үүрэг**

#### **6.1 Үйлчлүүлэгчийн үүрэг**

- 6.1.1. Аудитын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл, бололцоог бүрэн хангах;
- 6.1.2. Аудитын үйл ажиллагаанд үйлчлүүлэгчийн хяналт, оролцоотойгоор хийгдэх ажлын жагсаалтыг гаргаж өгөх;
- 6.1.3. Аудитын үйл ажиллагаанд шаардлагатай мэдээллийг гаргаж өгөх; (Эрчим хүчний хэрэглээний мэдээлэл, техник эдийн засгийн үзүүлэлт, тоног төхөөрөмжийн техникийн бичиг баримт, технологийн схем, туршилтын дүн гэх мэт).
- 6.1.4. Аудитын үйл ажиллагаанд шаардлагатай өөрийн өмчийн хэмжилтийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг гүйцэтгэгчид ашиглуулах асуудлыг энэ гэрээний 3.2-т заасан аудитын төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх зэргээр аудитын үйл ажиллагааг дэмжиж ажиллах.

6.1.5 Захиалагч нь гэрээний 3.2, 3.3, 6.1.1, 6.1.2, 6.1.3 зүйлийг хэрэгжүүлэх зорилгоор ахлах инженер Т.Ангарагаар удирдуулсан баг томилож өгөх.

6.1.6 Захиалагч талын эрчим хүчний хэмнэлтийн менежерээр ахлах инженер Т.Ангарагийг томилон ажиллуулах.

## **6.2. Үйлчлүүлэгчийн эрх**

6.2.1. Аудитын дүгнэлт, зөвлөмжийн талаар санал, хүсэлт, гомдол гаргах;

6.2.2. Гэрээний гүйцэтгэлтэй холбоотой нэмэлт мэдээлэл, тайлбар тодруулга, зөвлөгөө авах;

6.2.3. Үйлчлүүлэгчээс үл шалтгаалж гэрээний хугацаа хойшлох, бүрэн зогсоход хүрвэл гэрээг сунгах буюу цуцлах асуудлыг гүйцэтгэгчид тавих;

## **6.3. Гүйцэтгэгчийн үүрэг**

6.3.1. Аудитын үйлчилгээг Монгол Улсын хууль, холбогдох дүрэм, журмын дагуу мэргэжил, ёс зүйн өндөр түвшинд гүйцэтгэх;

6.3.2. Аудитын явцад танилцсан, цуглуулсан бүх баримт бичиг, мэдээллийг зөвхөн аудитын үйл ажиллагаанд ашиглах ба байгууллагын бизнесийн нууцтай холбоотой аливаа асуудлыг бусдад задруулахгүй байх;

6.3.3. Үйлчлүүлэгчид эдийн засгийн үр ашигтай, техникийн үндэслэлтэй зөвлөмжийг гаргаж өгөх;

6.3.4. Үйлчлүүлэгчийн хүсэлтээр аудитын зөвлөмж, дүгнэлтийн үндэслэлийг тайлбарлах, нотлох;

6.3.5. Аудит хийх явцад үйлчлүүлэгчийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаатай холбогдох дотоод дүрэм, журам, зааврыг мөрдөж ажиллах;

6.3.6. Аудитын хариуцлагын даатгалд даатгуулах асуудлыг бүрэн хариуцах;

6.3.7. Аудитын үйл ажиллагаанд үйлчлүүлэгчийн хяналт, оролцоотойгоор хийгдэх ажилд үйлчлүүлэгчээс томилсон ажилтантай хамтран ажиллах;

6.3.8. Үйлчлүүлэгч аудитын зөвлөмжийн дагуу эрчим хүч хэмнэлтийн арга хэмжээг хэрэгжүүлэх явцад нь шаардлагатай заавар, зөвлөмж өгч ажиллана.

## **6.4. Гүйцэтгэгчийн эрх**

6.4.1. Гүйцэтгэгч гэрээний хугацаанд аудит хийх барилга, байгууламжид үйлчлүүлэгчээс олгосон үнэмлэхээр нэвтрэх;

6.4.2. Гүйцэтгэгч аудитын үйл ажиллагаанд шаардлагатай тайлбар, материалыг үйлчлүүлэгчээс гаргуулж авах, шаардах;

6.4.3. Үйлчлүүлэгчийн техник, тоног төхөөрөмж, технологи, барилга, байгууламжийн нөхцөл байдал, үйл ажиллагаатай танилцах;

6.4.4. Үйлчлүүлэгчийн холбогдох ажилтнуудаас ярилцлага, тайлбар, тодруулга авах;

6.4.5. Үйлчлүүлэгчээс шалтгаалж аудитын үйл ажиллагаа удааширвал гэрээний хугацааг сунгах талаар үйлчлүүлэгчид санал тавих;

6.4.6. Аудитын үйл ажиллагаанд үйлчлүүлэгчийн өмчийн хэмжилтийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг энэхүү гээний 3.2-т заасан аудитын төлөвлөгөөнд тусгасны үндсэн дээр ашиглах эрхтэй.

#### **Долоо. Талуудын хариуцлага, маргаан шийдвэрлэх арга зам**

7.1. Талуудын аливаа буруутай үйл ажиллагаанаас шалтгаалж аль нэг талд хохирол учирсан бол буруутай тал хохиролыг бүрэн хариуцна.

7.2. Гүйцэтгэгч аудитын үйлчилгээг хугацаанд нь гүйцэтгээгүй бол хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн ... хувийн алданги төлнө.

7.3. Үйлчлүүлэгч аудитын үйлчилгээний хөлсийг энэхүү гэрээний 5.5-д заасан хугацаанд төлөөгүй бол хугацаа хэтэрсэн хоног тутамд төлөөгүй үнийн дүнгийн ... хувьтай тэнцэх алдангийг гүйцэтгэгчид төлнө.

7.4. Талууд энэхүү гэрээтэй холбоотой аливаа маргааныг харилцан зөвшилцөн шийдвэрлэх зарчмыг баримтална.

7.5. Талуудын хариуцлага нь Монгол Улсын Иргэний хууль болон бусад хуульд нийцсэн байх ба аль нэг талын эрх ашгийг хэт дордуулсан зохицуулалтыг нөгөө талдаа тулгахыг хориглоно.

7.6. Маргааныг харилцан зөвшилцөж, шийдвэрлэж чадахгүй бол Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлд хандаж шийдвэрлүүлнэ.

7.7. Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлийн гаргасан шийдвэрийг эс зөвшөөрсөн тохиолдолд шүүхэд гомдол гаргаж болно.

#### **Найм. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, цуцлах үндэслэл, гэрээг дуусгавар болгох**

8.1. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

8.2. Аудитын явцад гэрээнд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж талуудын гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

8.3. Гэрээг цуцлах үндэслэлийг Монгол Улсын хууль, тогтоомжид нийцүүлэн талууд харилцан тохиролцон тогтоож болно.

8.4. Учуруулсан хохирлыг арилгахтай холбогдсон хууль тогтоомжид заасан үндэслэлээр 2 тал харилцан тохиролцож гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж болно.

8.5. Гэрээнд заасан хугацаа дууссан өдрөөр гэрээг дуусгавар болсонд тооцно.

#### **Ес. Бусад**

9.1 Талууд гэрээг Монгол хэлээр хоёр хувь үйлдэх ба нэг, нэг хувийг хадгална.

9.2. Талууд гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс эхэлж гэрээ хүчин төгөлдөр болно.

9.3. Энэхүү гэрээний хавсралт болох “Аудитын төлөвлөгөө” нь гэрээний салшгүй хэсэг болно.

### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

#### ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР:

Э.МӨНХЖАРГАЛ

САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД  
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ:

О.УДВАЛ

АЖ АХУЙ, ХАНГАМЖИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА:

Г.БАТТУЛГА

АХЛАХ ИНЖЕНЕР:

Т.АНГАРАГ

ХУУЛИЙН

МЭРГЭЖИЛТЭН:

Г.САРУУЛ

ГЭРЭЭ БОЛОВСРУУЛСАН  
ХАНГАМЖИЙН МЭРГЭЖИЛТЭН:

М.МОЛОМЖАЕ

Хаяг: Монгол улс, Улаанбаатар  
хот, Баянзүрх дүүрэг, 8-р хороо, УС-15-1-1  
Утасны дугаар: 77111251  
РД: 6021646

#### ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ж.ОЮУНЦЭЦЭГ

Tel: 88111460

ЭДИЙН ЗАСАГЧ, ЕРӨНХИЙ  
НЯГТЛАН БОДОГЧ:

Д.БАЯРМАА

МАРКТЕНГ МЕНЕЖЕР:

А.НАМУУНАА

Хаяг: Монгол улс, Улаанбаатар  
хот, Хан-Уул дүүрэг, 1-р хороо, Эрэл-38-1.  
Утасны дугаар: 88111460  
РД: 5636531